2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт                                                  | Тайлант оны           |                | Зөрүү           | Хувь   |
|-----------------------|-----------------------------------------------------------|-----------------------|----------------|-----------------|--------|
|                       |                                                           | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |                 |        |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл          | -                     | 36,122,292.75  | (36,122,292.75) | -      |
| 2                     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 714,649,300.00        | 620,077,817.96 | 94,571,482.04   | 86.77  |
| 21                    | УРСГАЛ ЗАРДАЛ                                             | 714,649,300.00        | 620,077,817.96 | 94,571,482.04   | 86.77  |
| 210                   | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                           | 714,649,300.00        | 620,077,817.96 | 94,571,482.04   | 86.77  |
| 2101                  | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                         | 311,288,300.00        | 299,185,668.52 | 12,102,631.48   | 96.11  |
| 210101                | Үндсэн цалин                                              | 199,724,700.00        | 201,768,776.88 | (2,044,076.88)  | 101.02 |
| 210102                | Нэмэгдэл                                                  | 71,720,800.00         | 67,814,710.96  | 3,906,089.04    | 94.55  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 5,796,000.00          | 1,705,000.00   | 4,091,000.00    | 29.42  |
| 210104                | Урамшуулал                                                | 34,046,800.00         | 27,897,180.68  | 6,149,619.32    | 81.94  |
| 2102                  | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл            | 43,911,100.00         | 39,953,676.04  | 3,957,423.96    | 90.99  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                        | 29,859,600.00         | 28,680,826.54  | 1,178,773.46    | 96.05  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                        | 3,512,900.00          | 3,113,918.89   | 398,981.11      | 88.64  |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                         | 2,810,400.00          | 2,397,055.10   | 413,344.90      | 85.29  |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                      | 702,300.00            | 461,895.23     | 240,404.77      | 65.77  |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                     | 7,025,900.00          | 5,299,980.28   | 1,725,919.72    | 75.43  |
| 2103                  | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                 | 23,371,100.00         | 22,863,691.40  | 507,408.60      | 97.83  |
| 210301                | Гэрэл, цахилгаан                                          | 3,964,100.00          | 3,141,871.00   | 822,229.00      | 79.26  |
| 210302                | Түлш, халаалт                                             | 19,107,000.00         | 18,540,999.40  | 566,000.60      | 97.04  |
| 210303                | Цэвэр, бохир ус                                           | 300,000.00            | 1,180,821.00   | (880,821.00)    | 393.61 |
| 2104                  | Хангамж, бараа материалын зардал                          | 37,850,000.00         | 31,774,496.00  | 6,075,504.00    | 83.95  |
| 210401                | Бичиг хэрэг                                               | 2,599,600.00          | 2,894,300.00   | (294,700.00)    | 111.34 |
| 210402                | Тээвэр, шатахуун                                          | 28,750,000.00         | 25,602,015.00  | 3,147,985.00    | 89.05  |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 1,500,000.00          | 978,800.00     | 521,200.00      | 65.25  |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,400.00          | 1,999,591.00   | 809.00          | 99.96  |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 3,000,000.00          | 299,790.00     | 2,700,210.00    | 9.99   |
| 2105                  | Норматив зардал                                           | 55,952,100.00         | 55,465,293.00  | 486,807.00      | 99.13  |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                           | 44,069,400.00         | 43,588,844.00  | 480,556.00      | 98.91  |
| 210502                | Хоол, хүнс                                                | 11,882,700.00         | 11,876,449.00  | 6,251.00        | 99.95  |
| 2106                  | Эд хогшил, урсгал засварын зардал                         | 142,310,400.00        | 138,361,890.00 | 3,948,510.00    | 97.23  |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл                                   | 63,570,000.00         | 63,412,890.00  | 157,110.00      | 99.75  |
| 210602                | Тавилга                                                   | 32,000,000.00         | 31,927,200.00  | 72,800.00       | 99.77  |
| 210603                | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                              | 23,780,400.00         | 23,454,000.00  | 326,400.00      | 98.63  |
| 210604                | Урсгал засвар                                             | 22,960,000.00         | 19,567,800.00  | 3,392,200.00    | 85.23  |
| 2107                  | Томилолт, зочны зардал                                    | 2,499,600.00          | 2,443,500.00   | 56,100.00       | 97.76  |
| 210702                | Дотоод албан томилолт                                     | 2,499,600.00          | 2,443,500.00   | 56,100.00       | 97.76  |

|               |                                                          |                |                |                 |        |
|---------------|----------------------------------------------------------|----------------|----------------|-----------------|--------|
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                   | 97,466,700.00  | 30,029,603.00  | 67,437,097.00   | 30.81  |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 97,466,700.00  | 30,029,603.00  | 67,437,097.00   | 30.81  |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | 714,629,300.00 | 671,145,440.00 | 43,483,860.00   | 93.92  |
| <b>1320</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | 25,752,300.00  | 25,752,300.00  | -               | 100.00 |
| 132001        | Орон нутгийн төсвөөс                                     | 25,752,300.00  | 25,752,300.00  | -               | 100.00 |
| <b>1340</b>   | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>      | 688,877,000.00 | 645,393,140.00 | 43,483,860.00   | 93.69  |
| 134002        | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                | 688,877,000.00 | 645,393,140.00 | 43,483,860.00   | 93.69  |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | -              | -              | -               | -      |
| 1200042       | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                | -              | -              | -               | -      |
| <b>4</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | -              | 36,122,292.75  | (36,122,292.75) | -      |
| <b>5</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> | -              | 84,652,306.19  | (84,652,306.19) | -      |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>                                   | 18.00          | 18.00          | -               | 100.00 |
| 620001        | Удирдах ажилтан                                          | 1.00           | 1.00           | -               | 100.00 |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан                                        | 13.00          | 13.00          | -               | 100.00 |
| 620003        | Үйлчлэх ажилтан                                          | 4.00           | 4.00           | -               | 100.00 |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төв нь зорилгоо “Бүхний эрүүл мэндийн төлөө хамтдаа зүтгэн, сумын эрүүл мэндийн төвийн стандартын хангалтыг сайжруулан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлнэ” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сумын хүн амд чанартай, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/A/118 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам ”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70,908.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөгөөр/                         |                     |                     |                  |
|--------------------------------------------|---------------------|---------------------|------------------|
| Үзүүлэлт                                   | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт         |
| Б                                          | 1                   | 2                   | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                             | 36,122.29           | 84,652.31           | 48,530.02        |
| Авлага                                     | 172,552.00          | 19,602.76           | (152,949.24)     |
| Бараа материал                             | 98,320.66           | 176,819.91          | 78,499.25        |
| Үндсэн хөрөнгө                             | 734,806.70          | 831,634.91          | 96,828.21        |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                  | <b>1,041,801.65</b> | <b>1,112,709.89</b> | <b>70,908.24</b> |
| Өглөг                                      | 6,492.98            | 30.00               | (6,462.98)       |
| Засгийн газрын хувь оролцоо                | 481,147.29          | 481,147.29          | -                |
| Хуримтлагдсан үр дүн                       | 466,132.71          | 543,503.93          | 77,371.22        |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү           | 88,028.67           | 88,028.67           | -                |
| <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>1,041,801.65</b> | <b>1,112,709.89</b> | <b>70,908.24</b> |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 48,530.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 152,949.2 мянган төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,499.3 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 28,669.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 70,908.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 118,764.7 мянган төгрөгийн, хандиваар 52,109.9 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авснаас шалтгаалсан байна.

Өглөгийн дансны үлдэгдэл 6,462.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өглөгийг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 25,752.3 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 688,877.0 мянган төгрөгийн, нийт 714,629.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл



Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 зорилтын 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 714,629.3 мянган төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 25,752.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 688,877.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 25,752.3 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 645,393.1 мянган төгрөгийн, нийт 671,145.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 503,850.7 мянган төгрөгийг зарцуулж, 84,652.3 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 620,077.8 мянган төгрөг буюу 86,8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 12,102.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 507.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 6,075.5 мянган төгрөг, нормативд зардал 486.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 3,948.5 мянган төгрөг, томилолт, зочны зардал 56.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 67,437.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

| /мянган төгрөгөөр/ |                                             |                   |                   |                  |              |
|--------------------|---------------------------------------------|-------------------|-------------------|------------------|--------------|
| д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ                       | Төлөвлөгөө        | Гүйцэтгэл         | Зөрүү            | Биелэлт      |
| 1                  | <b>71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>    |                   |                   |                  |              |
| 1.1                | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал         | -                 | 351.00            | (351.00)         | -            |
| 1.2                | 80111-Төрийн байгууллагын тогтмол зардал    | -                 | 53,989.38         | (53,989.38)      | -            |
| 1.3                | 80112-Нийтлэг үйлчилгээ                     | 1,081.20          | 1,081.20          | -                | 100.00       |
| 1.4                | 80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 294,640.80        | 269,709.79        | 24,931.01        | 91.54        |
| 1.5                | 81602-Анхан шатны тусламж үйлчилгээ         | -                 | 2,451.16          | (2,451.16)       | -            |
| 1.6                | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ   | 192,163.70        | 168,334.88        | 23,828.82        | 87.60        |
| 1.7                | 83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 202,072.50        | 156,367.30        | 45,705.20        | 77.38        |
| <b>Дүн</b>         |                                             | <b>689,958.20</b> | <b>652,284.71</b> | <b>37,673.49</b> | <b>94.54</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтад үндэслэн холбогдох тайлан мэдээг үнэн зөв бэлтгэж байх, батлагдсан төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулан авлага, өр төлбөр үүсгэхгүй байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 593,867.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,908.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,681.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 12,102.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 507.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 6,075.5 мянган төгрөг, норматив зардал 486.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 3,948.5 мянган төгрөг, томилолт, зочны зардал 56.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 67,437.1 мянган төгрөгөөр хэмнэлтийг бий болгосон боловч цэвэр бохир усны зардлыг 880.8 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 294.7 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулж, хэмнэлт үүсгээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 104 мэдээллийг хугацаандаа, 65 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш ажил гүйлгээнээс нийт 125,621.7 мянган төгрөгийн 15 ажил гүйлгээг мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Бүрэн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 100,767.5 мянган төгрөгийн 10 зөрчил илэрч, 1,186.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 27,423.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 72,157.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт 93,3 хувьтай.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт   |                  |             |
|-----------------|------------------------|------------------|-----------|------------------|-------------|
|                 | Тоо                    | Дүн              | Тоо       | Дүн              | Хувь        |
| Албан шаардлага | 3                      | 27,423.4         | 3         | 27,423.4         | 100.0       |
| Төлбөрийн акт   | 2                      | 1,186.4          | 2         | 1,186.4          | 100.0       |
| Зөвлөмж         | 5                      | 72,157.7         | 4         | 72,157.7         | 80.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>10</b>              | <b>100,767.5</b> | <b>10</b> | <b>100,767.5</b> | <b>93.3</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 29,732.7 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 29,732.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### **5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Авлага, өглөгийн данстай холбоотой**

##### Илрүүлэлт:

Тайлант онд 19,602.8 мянган төгрөгийн авлага, 30.0 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулан, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

#### **2. Цалин хөлстэй холбоотой**

##### Илрүүлэлт:

Тайлант онд цалингийн цэсээр олгосон цалинг НДШ төлөлтийн тайлантай тулгахад цалингийн цэсээр олгосон цалинг 1,894.4 мянган төгрөгөөр НДШ төлөлтийн тайланд илүү тайлагнасан байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-д "Шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад үндэслэн холбогдох тайлан, мэдээг үнэн зөв бэлтгэн тайлагнаж байх.

#### **3. Зардлын данстай холбоотой**

##### Илрүүлэлт:

Тайлант онд төсвийг бодитой төлөвлөөгүйгээс цэвэр бохир усны зардлыг 787.8 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 294.7 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, аж ахуйн эд зүйлийн зардлыг 7,123.0 мянган төгрөгөөр тус тус батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                        | Нийт зөрчил |                 | Үүнээс        |     |                 |     |          |                 |                                      |                     |                                                 |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----|----------|-----------------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|
|                                                                                                                                                                                                                                                           |             |                 | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |                 | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|                                                                                                                                                                                                                                                           | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн             | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |
| Тайлант онд цэвэр бохир усны зардлыг 787.8 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 294.7 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, аж ахуйн эд зүйлийн зардлыг 7,123.0 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, хэмнэлт үүсгээгүй | 1           | 8,205.5         | -             | -   | -               | -   | 1        | 8,205.5         | -                                    | -                   | -                                               | -   |
| Тайлант онд 19,602.8 мянган төгрөгийн авлага, 30.0 мянган төгрөгийн өглөг үүссэн                                                                                                                                                                          | 1           | 19,632.8        | -             | -   | -               | -   | 1        | 19,632.8        | -                                    | -                   | -                                               | -   |
| Тайлант онд цалингийн цэсээр олгосон цалинг НДШ төлөлтийн тайлантай тулгахад цалингийн цэсээр олгосон цалинг 1,894.4 мянган төгрөгөөр НДШ төлөлтийн тайланд илүү тайлагнасан                                                                              | 1           | 1,894.4         | -             | -   | -               | -   | 1        | 1,894.4         | -                                    | -                   | -                                               | -   |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                | <b>3</b>    | <b>29,732.7</b> | -             | -   | -               | -   | <b>3</b> | <b>29,732.7</b> | -                                    | -                   | -                                               | -   |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                           | Нийт зөрчил |                  | Үүнээс        |     |                 |                  |         |     |     |     |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|---------|-----|-----|-----|
|                                                                                                                                                                                                                                                              |             |                  | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                  | Зөвлөмж |     |     |     |
|                                                                                                                                                                                                                                                              | Тоо         | Дүн              | Тоо           | Дүн | Тоо             | Дүн              | Тоо     | Дүн | Тоо | Дүн |
| <u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>                                                                                                                                                                                              |             |                  |               |     |                 |                  |         |     |     |     |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 104 мэдээллийг хугацаандаа, 65 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш ажил гүйлгээнээс нийт 125,621.7 мянган төгрөгийн 15 ажил гүйлгээг мэдээлээгүй байна. | 1           | 125,621.7        | -             | -   | 1               | 125,621.7        | -       | -   | -   | -   |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                   | <b>1</b>    | <b>125,621.7</b> | -             | -   | <b>1</b>        | <b>125,621.7</b> | -       | -   | -   | -   |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)